



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 92

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 64.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3,590,566.06 (гурван сая таван зуун ерэн мянга таван зуун жаран зургаан төгрөг зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, 844,838.88 (найман зуун дөчин дөрвөн мянга найман зуун гучин найман төгрөг наян найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Т.Азбаяр, "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Мөнгөнхөлөгт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг хөлбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах

2.3.Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132004615  
7-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 03 дугаар сарын 08 -ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, "Багануур зүүн өмнөд  
бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-нд балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ(төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл(төгрөг)	Үлдэх өртөг(төгрөг)
1	Эрчим хүчний дэд станц	1983	1	ш	3,590,566.06	844,838.88	2,745,727.18